



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

2022

Жилийн тайлан

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

2022 он хөрөнгө оруулагч нарын хувьд тун амаргүй жил байлаа. S&P 500 индекс 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн өндөр уналттай жил болж өнгөрлөө.

Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индекс 12 сарын 31-ний байдлаар он гарснаас хойш 15 хувиар уналттай байсан ба Монголын улсын хэмжээнд инфляцын түвшин буурахгүй байгаа нь бодлогын хүүгийн хүчтэй өсөлтийг сааруулах нөхцөл байдал ажиглагдахгүй байгаа нь хөрөнгийн зах зээл өсөхөд саад болсоор байна.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төрийн өмчит 25 компанийн 34 хувийг олон нийтэд санал болгон худалдаж нээлттэй компани болгохоор тусгасны дагуу "Монголын Хөрөнгийн Бирж" хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгож нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх захиалгаа эхлүүлсэн ба зах зээлээс нийт 57.8 тэрбум төгрөгийн захиалга хөрөнгө оруулагчдаас ирсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 4.8 дахин давсан үзүүлэлт боллоо.

"Үндэсний Хувьчлалын Сан" ХОС нь Монгол Улсын төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож нэгж эрх эзэмшигч нартаа ашиг хүртээх эрхэм зорилгынхоо хүрээнд 6,100 гаруй нэгж эрх эзэмшигчдийнхээ өмнөөс Монголын Хөрөнгийн Биржийн хувьчлалд стратегийн хөрөнгө оруулагчаар орж нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг өсөн нэмэгдүүлэх дээр хичээнгүйлэн ажиллаж байна.

2023 он та бидний хөрөнгө улам өсөн арвижсан сайхан жил болно гэдэгт итгэлтэй байна.

Сангийн менежер

Ч.Даваасамбуу

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:XOC) нь 2020 оны 10 дугаар сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 2 жил 4 сарын хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮7 тэрбумд хүрч чамлахааргүй өсөлтийг үзүүлжээ. 2022 оны эцсийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮141.00 хүрч оны эхнээс 24.4% буурсан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 41%-иар өсөөд байна.
- ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг нээлттэй хувьцаануудад түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба Монголын хөрөнгийн зах зээл нь гадаад дотоодын нөлөөллөөр 2022 онд 15 хувиар унаад байгаа билээ. Үүний нөлөөгөөр ХОС-ийн цэвэр хөрөнгө 24.4 хувиар унасан үйл явдал боллоо.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2019	2020	2021	2022
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж		25.6%	91.2%	-24.4%
ТОП-20-ийн өгөөж	-8.6%	-1.7%	130%	-15.4%
Хадгаламжийн хүү	13.5%	11.3%	~9%	10.3%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
6,127

Нэгж эрхийн хаалтын ханш
₮112.58

Зах зээлийн үнэлгээ
₮5.63 тэрбум

Жилийн арилжааны эргэлт
₮692.3 сая

Нэгж эрхийн NAV
₮141.0

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮7.05 тэрбум

ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн дарга**

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК”
ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн
санхүү эрхэлсэн захирал, “Ард Менежмент ҮЦК”
ХХК-ийн ТУЗ-ийн дарга



Чулуунбаатарын Хандаа

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч

Албан тушаал: “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-
ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Албан тушаал: ХҮИС-ийн НББ, Санхүүгийн тэнхим
ахлах багш



Баяраагийн Баасандорж

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Эрх зүйч

Албан тушаал: “Батбаяр Энд Партнэрс” ХХН-д
өмгөөлөгч, МУИС, Санхүү, татварын эрх зүйн багш

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



Чадраабал Даваасамбуу

Мэргэжил: Санхүү, Хөрөнгө оруулалт

Албан тушаал: “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
сангийн менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг болно.


НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2022 оны эхэнд Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,325 байсан бол оны эцсийн байдлаар 6,127-д хүрч 3%-иар буурсан байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо өмнөх жилийнхтэй ойролцоо түвшинд байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгаа зэргийг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,734,408	11%
А. ТУЛГА	3,000,000	6%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ ХХК	2,500,000	5%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК	2,500,000	5%
АРД КРЕДИТ ББСБ ХК	1,558,998	3%
БОГД БАНК ХК	1,371,500	3%
С. МАНДАХБАЯР	1,000,000	2%
Г. НАРАНБАТ	1,000,000	2%
Ж. ЦЭРЭНДОЛГОР	807,141	2%
АРДЫН ТЭТГЭВЭРИЙН ДАНС ХХК	803,930	2%
МОНРЕ ДААТГАЛ ХХК	500,000	1%
Бусад 6,116	29,266,135	59.0%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


ХОС нь 2022 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2022 онд эцэст 7.05 тэрбум төгрөгт хүрч 24.4%-иар, зах зээлийн үнэлгээ нь 5.63 тэрбум төгрөгт хүрч 43.4%-иар тус тус буурчээ. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 41%-иар өсөөд байна. Тайлант хугацаанд ХОС-ийн татварын дараах алдагдал 2.27 тэрбум төгрөг, татварын зардал 254 сая төгрөг байлаа.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
12/31/2022	112.58	141.02
Оны эхнээс %	-43.40%	-24.40%
Сан нээгдсэнээс хойш	12.60%	41.00%
2022 оны дээд доод	198.89-100.94	192.02-116.55

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт
(сая төгрөг)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ын хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 78 хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийсэн. Мөн тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл багцдаа нэмж багцын 14 орчим хувьд хүргэсэн.

Эдийн засгийн нэг салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ сангийн хөрөнгийн 25%-с хэтрэхгүй байхаар журамлагдсан бөгөөд дээр дурдсанчлан өртгийн аргаар тооцоход харьцаа үзүүлэлтийг хангаж байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 26 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 20 нь дотоодын хувьцаа, 6 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 10, өргөн хэрэглээний 4, түүхий эдийн 3, аж үйлдвэрийн 2, тогтмол бус хэрэглээний 3, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

Хувьцааны багц, эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,883.6 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 329 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн дундаж үлдэгдлээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2022 онд 4.7% байна.

Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 82%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК


Нийт ажиглалтын тоо 248 бөгөөд өдрийн стандарт хазайлт нь 1.26% буюу жилийн 19.92% болно. Эрсдэлгүй хүүг Монголбанкны бодлогын хүү болох 13%-р тооцвол, Sharpe ratio (эрсдэлээр жигнэсэн өгөөжийг илтгэдэг харьцаа) нь 1.92 гарч байна.

НОГДОЛ АШИГ ТАРААХ ТУХАЙ ШИЙДВЭР

Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 23/01 тоот тогтоолоор “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу 2022 оны цэвэр ашгаас нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхэд 2.3 (хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашиг авах эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан нэгж эрх эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ын нэгж эрхийн арилжааны эргэлт 2022 онд ₮692.3 сая байгаа ба нийт 5.1 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 10.2 хувь гар сэлгэсэн байна.



САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сангийн менежер Ч.Даваасамбуу нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегиар хөрөнгө оруулалтууд хийдэг ба 2022 онд Монголын болон гадаадын хөрөнгийн зах зээл өндөр бууралттай жил байсан нь цэвэр хөрөнгийн үнэлгээг 24.4 хувиар буураалаад байгаа билээ.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банкинд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Ковид-19 цар тахалын дараах эдийн засгийн идэвхжилтээс үүдэн нэмэгдсэн эрэлтийг бүрэн сэргэж амжаагүй тээвэр ложистикийн системийн нийлүүлэлт бүрэн хангаж чадаагүйгээс үүдэн 2021 онд дэлхий даяар өндөр үнийн өсөлт бий болж тэр нь өнөөдрийг болтол үргэлжилсээр байгаа билээ. Мөн Орос-Украины дайны улмаас европын холбооны улсуудад эрчим хүчний үнийн өсөлт бий болж нөхцөл байдлыг улам л дордуулсан. Энэхүү удаан үргэлжилж буй хэт өндөр инфляцийг бууруулахын тулд улс орнуудын төв банкууд бодлогын хүүгээ эрчимтэй нэмэгдүүж мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь эдийн засагт болоод хөрөнгийн зах зээлд таатай нөлөө үзүүлсэнгүй. Дэлхийн улс орнуудийн 2022 оны ДНБ-ны өсөлтийн түвшин өмнөх оны үзүүлэлтээс буурсан байгаа нь бодлогын хүүний өсөлттэй шууд хамааралтай билээ.


ДНБ болон инфляцын жилийн өсөлтийн харьцуулалт(2021, 2022 он)

Эдийн засгийн үзүүлэлт	Улс	2021	2022	Зөрүү
ДНБ жилийн өсөлт	Монгол	4.6%	2.98%	-1.62%
	АНУ	5.60%	0.45%	-5.15%
	БНХАУ	8.10%	2.70%	-5.40%
	ЕХ	5.10%	3.30%	-1.80%
	Дэлхий	5.90%	2.90%	-3.00%
инфляцын жилийн өсөлт	Монгол	13.4%	13.2%	-0.20%
	АНУ	4.70%	6.50%	1.80%
	БНХАУ	0.90%	1.80%	0.90%
	ЕХ	2.60%	9.20%	6.60%
	Дэлхий	4.30%	8.75%	4.45%

Эх сурвалж: Блүүмбэрг

2022 оны хувьд дэлхийн хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд бүгд уналттай байсан бөгөөд АНУ-ын технологийн салбарын 100 компанийг багцалсан индекс болох NASDAQ нь хамгийн хүчтэй унаж оны эхний үнэлгээний 34%-ийг алджээ.

Голлох хөрөнгийн захын индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмбэрг

АНУ-ын Холбооны Нөөцийн Банкны 2022 онд 4.5% хүртэл өсгөсөн бодлогын хүүнээс шалтгаалж 2020 оны 7-р сард 0.5% байсан АНУ-ын ЗГ-ын бондын өгөөж 2022 оны 10 дугаар сард 4% болж сүүлийн 14 жилд байгаагүй өндөр түвшинд хүрчээ. Энэ нь хөрөнгө оруулагчдыг уналттай байгаа хувьцааны зах зээлд бус өгөөж нь тасралтгүй өссөөр байгаа өрийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах сэдлийг бий болгож байгаа билээ


10 жилийн хугацаатай АНУ-ын засгийн газрын бондын өгөөж



Эх сурвалж: Блүүмбэрг

Монголбанкны зүгээс инфляцийн түвшин бууруулах зорилгоор 2022 онд бодлогын хүүгээ 5 удаа нэмэгдүүлж 13%-д хүргээд байгаа билээ. Үр дүнд нь 2022 оны 6-р сард 17%-д хүрээд байсан инфляцийн түвшин тухайн оны эцсийн байдлаар 13.2%-д хүрч буураад байна. Монголбанкны шинжээчдийн үзэж буйгаар бол 2024 оны нэгдүгээр улирал гэхэд инфляцийг зорилтот түвшин болох $6\pm 2\%$ -д хүрэх төсөөлөлтэй байгаа аж.


Монголбанкны бодлогын хүү болон инфляцын хамаарал



Эх сурвалж: Монгол Банк

Нөгөөтэйгүүр бодлогын хүүний өсөлт нь банкуудийн хадгаламж болон засгийн газрын үнэт цаасны өгөөжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл бөгөөд энэ нь нийт хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлж зах зээл дээрх мөнгөний эргэлтийг бууруулдаг. Мөн тогтмол төлбөр бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн нэрлэсэн өгөөжийг нэмэгдүүлсэнээр хөрөнгө оруулагчдыг хувьцааны заххаас илүү бонд, ХБҮЦ, ЗГҮЦ зэрэг хэрэгслүүд рүү хандуулж хөрөнгийн зах зээлийн уналтын шалтгаан болдог билээ.

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2023 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Дэлхийн улс орнууд 2023 онд мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэх хэрэгжүүлсэнээр инфляцийн түвшинг тогтворжуулж чадна гэсэн хүлээлтэй байгаа бөгөөд 2024 он гэхэд зорилтот түвшинд хүрнэ гэж таамаглаж байгаа аж. Гэвч энэ нь нөгөө талаараа эдийн засгийн идэвхийг сулруулж, зах зээл дэх мөнгөний эргэлтийг бууруулсанаар эдийн засгийн өсөлтийг сааруулах үр дагавартай. Тэр ч утгаараа дэлхийн улс орнууд ирэх жилүүдийн ДНБ-ны өсөлтийг доогуур төсөөлсөн байна.

ДНБ болон инфляцын өсөлтийн таамаглал

Макро үзүүлэлт	Улс	2022	2023	2024
Бодит ДНБ жилийн өсөлт	Дэлхий	2.9%	1.7%	2.7%
	АНУ	0.45%	0.7%	1.65%
	Монгол улс	4.0%	5.3%	6.4%
Инфляцийн жилийн өсөлт	Дэлхий	6.9%	4.5%	2.9%
	АНУ	6.5%	1.9%	1.5%
	Монгол улс	13.2%	9.11%	6.44%

Эх сурвалж: Блүүмбэрг


Өнгөрсөн 2021 болон 2022 онуудад БНХАУ-ын хувьд барилгын салбарын удаашрал, өвлийн олимптой холбоотой цар тахлын эсрэг хатуу дэглэм зэргээс үүдэлтэй эдийн засгийн өсөлт нь удаашралтай байсан бөгөөд үүний эсрэг БНХАУ-ны зүгээс бодлогын хүүгээ бууруулж байгаа нь бусад улс орнуудаас ялгаатай үйлдэл болж байлаа. Хятадын хөрөнгийн зах зээл засгийн газраас нь хэрэгжүүлсэн монополийн эсрэг болон технологийн компаниудын эсрэг бодлогоос үүдэн уналттай байсан. Тэгвэл 2022 оны сүүл үеэр БНХАУ-д “Тэг ковид” бодлогыг эсэргүүцсэн, хилийн хориг, хаалттай байдлаа өөрчлөх тэмцэл хурцаар өрнөсөний улмаас цар тахлын эсрэг баримталж байсан хатуу дэглэмээ сулруулахаар болсон билээ. Үр дүнд нь Хятадын хөрөнгийн зах зээл 2022 оны сүүл үеэр хүчтэй өсөлтийг үзүүлээд байгаа бөгөөд цаашид үргэлжлэн өсөх өндөр магадлалтай байгаа юм. Тиймээс БНХАУ-ын засгийн газрын бодлого болон АНУ-тай хийж буй худалдааны дайны байр байдлыг сайтар ажиглах шаардлагатай



Эх сурвалж: Блүүмбэрг

Монгол улсын 2022 оны ДНБ өсөлт 4.0% орчимд гарах хүлээлттэй байна. Азийн Хөгжлийн Банк болон Дэлхийн Банкны төсөөллөөс харвал 2023 онд Монгол улсын ДНБ өсөлт 5.3% байх төлөвтэй. Бодлогын хүү болон хадгаламжийн хүү өндөр байгаа бөгөөд банкуудын хөрвөх чадвар буурсан байгаа нь эдийн засаг дахь мөнгөний эргэлт буурсаны илгэж байна. Эзэмшиж буй төв банкны үнэт цаасны (ТБҮЦ) хэмжээгээр банкуудад байгаа илүүдэл мөнгөний хэмжээг баримжаалж болдог. Тэгвэл 2022 оны 12-р сарын эцсийн байдлаар банкууд дээр нийт ₮5.7 их наядын ТБҮЦ байгаа нь өмнөх оны мөн үеэс 34% буурсан үзүүлэлт юм.

Банкуудын эзэмшиж буй төв банкны үнэт цаасны хэмжээ (ТБҮЦ)



Эх сурвалж: Монгол Банк



Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 13110

Room 1502, Level 15
Union Building - B, Paris Street
Narii Zam - 62, Khoroo - 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 13110

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, Парисын
гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС ХХК -ийн Нэгж эрх эзэмшигчдэд

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

“Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС ХХК (‘ХОС’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2022 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь ‘ХОС’-ийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЭЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан) болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу ‘ХОС’-аас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн дүгнэлтээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан асуудлууд юм. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайланд бүхэлд нь аудит хийж, дүгнэлт гаргахдаа авч үзсэн бөгөөд бид эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгөхгүй.

Аудитын гол асуудал

Аудитын хариу

1 Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт

“ХОС”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан дах Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөд арилжаалах зорилгоор эзэмшиж буй, хөрөнгийн бирж дээр нээлттэй арилждаг өмчийн болон өрийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтууд багтдаг бөгөөд ХОС-н удирдлага энэхүү санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэмжилтийг гүйцэтгэхэд тооцоолол болон шийдэл шаарддаг гэж үзсэн тул аудитын гол асуудалд оруулсан. Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 10-аас үзнэ үү.

Бид санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ нээлттэй арилжаалагддаг гадаад болон дотоодын хөрөнгийн бирж дээрх арилжааны түүхэн мэдээлэл болох хувьцааны нээлт хаалтын ханш, тоо ширхэг, арилжааны давтамж зэргийг олж танилцсан. Мөн тэдгээр компаниудын үйл ажиллагаатай холбоотой томоохон үйл явдал, биржээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судалсан.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.

Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитетийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

3



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материалаагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь 'ХОС'-г татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх 'ХОС'-ийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн сүүрийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь 'ХОС'-ийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн сүүрийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахүйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид эдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл хариу арга хэмжээ зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.



Л. БАЯРЦОГЗОЛ
"БДО Аудит" ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Парисын гудамж, Нарны зам-62
Юнион Бюдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2023 .04. 03

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 7,318 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 7,051 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2021 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө 25.8%, цэвэр хөрөнгийн дүн 24.4%-ийн бууралтыг тус тус үзүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2021 Q4	2022 Q4
Нийт хөрөнгө	9,857	7,318
Мөнгө	251	276
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	8,948	6,651
Санхүүгийн хөрөнгө /Хорогдуулсан.Ө/	658	372
Авлага	-	19
Нийт өр төлбөр	531	267
Дансны өглөг	25	45
Орлогын татварын өр	7	7
Хойшлогдсон татварын өр	499	215
Эздийн өмчийн дүн	9,325	7,051
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	4,325	2,051

ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2021 Q4	2022 Q4
Хүүгийн орлого	204	121
Ногдол ашгийн бодлого	90	106
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	4,935	(2,640)
Нийт ашиг (алдагдал)	5,229	(2,413)
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(202)	(177)
Кастодианы үйлчилгээний зардал	(28)	(25)
Бусад зардал	(39)	(127)
Нийт үйл ажиллагааны зардал	(269)	(329)
Татварын өмнөх ашиг	4,959	(2,543)
Хойшлогдсон татварын зардал	(512)	268
Тайлант үеийн цэвэр ашиг	4,447	(2,275)